



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/33

Бодь

┌ Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг
Сурталчлах иргэдэд экологийн боловсрол
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дугаар заалт, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны 4.2.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан журмын 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Байгалийн амьтан, ургамал хамгаалах дэлхийн өдөр”, “Дэлхийн ойн өдөр”, “Дэлхийн усны өдөр”, “Дэлхийн цаг уурын өдөр” жил бүрийн 3 дугаар сард тохиодогтой уялдуулан ард иргэдэд хийх мэдээлэл, сургалт сурталчилгаа бусад арга хэмжээг “Газрын доорх үл харагдах усыг таниулья” сэдвийн дор сум орон нутгийн иргэд, төрийн албан хаагчид, сургууль, цэцэрлэгийн бүх шатны суралцагч нарт 2022 оны 03 дугаар сарын 20-ний өдрөөс 04 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Байгаль орчны тэмдэглэлт өдрийн ач холбогдол, мөн чанарыг иргэд, суралцагч нарт сурталчлан таниулж экологийн мэдлэг хандлага, төлөвшил олгох талаар олон талт ажил арга хэмжээ зохион байгуулж хэрэгжүүлэхийг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (С.Ганцэцэг)-д үүрэг болгосугай.

3.Иргэдэд экологийн боловсрол олгох сургалт, бусад спортын арга хэмжээнд зарцуулагдах 400.000 (дөрвөн зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Эрдэнэцэцэг), Нягтлан бодогч (Б.Батбаяр) нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



Р.БАТЖАРГАЛ

642201047

“ДЭЛХИЙН УСНЫ ӨДӨР”-ӨӨР ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
“ЗАЛУУ БАЙГАЛЬЧ” ЭКО КЛУБИЙН СУРАГЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ
ТЭМЦЭЭНИЙ ШАГНАЛЫН ЗАРДАЛ

2022 оны 03 дугаар сарын 20

Бодь

№	Тэмцээний төрөл	Байр	Шагналын дүн
А	2	3	5
1	АХА	1-р байр	25000
2	АХА	2-р байр	15000
3	АХА	3-р байр	10000
4	ДҮН		50000

_____оОо_____